

# Ганц бие өрхөд зориулсан богино хугацааны тусгай тэтгэмжийн танилцуулга

## Ганц бие өрхийг дэмжих зорилгоор тэтгэмжийн мөнгө олгохоор боллоо!

### 1. Үндсэн тэтгэмж

Хүүхдийн тэтгэмж авч байгаа ганц бие өрхүүдэд олгох тэтгэмж\*1

#### • Тэтгэмж олгох нөхцөл

■ Доорх ①-③ нөхцөлүүдийн аль нэгийг хангасан хүнд олгоно.

- ① 2020 оны 6-р сарын хүүхдийн тэтгэмж авах эрхтэй
- ② Нийгмийн халамж, тэтгэвэр\*2 авч байгаа бөгөөд 2020 оны 6-р сард хүүхдийн тэтгэмж нь бүрэн зогссон хүн\*3
- ③ Шинэ корона вирусийн халдварт өвчний нөлөөгөөр өрхийн байдалд өөрчлөлт гарч, хүүхдийн тэтгэмж авдаг хүнтэй ижил орлогын түвшинд хүрч байгаа хүн

\*1 Хүүхдийн халамжын тухай хуульд заасан “Асран хамгаалагч” мөн хамрагдана.

\*2 Тэжээгчээ алдсаны, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр насны, хөдөлмөрийн ослын тэтгэмжүүд ба тэжээгчээ алдсаны тусламж зэрэг багтана.

\*3 Хүүхдийн тэтгэмж авч байгаа хүнээс гадна, Хүүхдийн халамжийн хүсэлт гаргасан бөгөөд 2020 оны 6-р сарын халамжийн мөнгө нь бүрэн ба хэсэгчилэн зогссон байх магадлалтай хүнд хамаарна.

#### • Тэтгэмжийн мөнгөн дүн

1 өрхөд 50,000 иен, 2 дахь хүүхдээс хойших хүүхэд бүрт 30,000 иен

### 2. Нэмэлт тэтгэмж

Шинэ корона вирусийн халдварт өвчний нөлөөгөөр өрхийн байдалд өөрчлөлт орж, орлого багассан хүнд олгоно.

#### • Нэмэлт тэтгэмж олгох нөхцөл

Дээрх үндсэн тэтгэмжийн ① ба ② нөхцөлд хамрагдсан бөгөөд шинэ корона вирусийн халдварт өвчний нөлөөгөөр өрхийн байдалд өөрчлөлт орж, орлого багассан хүн.

#### • Тэтгэмжийн мөнгөн дүн

1 өрхөд 50,000 иен

Бүртгүүлэх заавар арын нүүрэнд байгаа тул сайтар уншина уу.

# Тэтгэмж авах хүсэлт гаргах

2020 оны 6-р сарын хүүхдийн тэтгэмж авах эрхтэй хүнд

(Эхний нүүрийн 1. ①-т хамрагдах хүн)

- ▶ Үндсэн тэтгэмж авахад хүсэлт гаргах шаарлагагүй.
- ▶ 8-р сарын үеэр 2020 оны 6-р сарын хүүхдийн тэтгэмж авсан дансанд орно.


## 【Анхаарах зүйлс】

- \* Тэтгэмж хэрэггүй бол танд явуулах хүсэлтийн хуудсыг буцааж явуулна уу.
- \* Хүүхдийн тэтгэмж хүлээн авдаг данс нь хаагдсан зэрэг тэтгэмж олголт саатах эрсдэлтэй бол дансны мэдээллээ шинэчилж мэдүүлнэ үү.

- ▶ Нэмэлт тэтгэмж авахад хүсэлт гаргах шаардлагатай.
- ▶ Ээлжит хяналтын үед (8-р сар) орлого багассан тухай мэдүүлэгт үндэслэн хүсэлтийг хялбаршуулсан байдлаар хүлээн авна. Хүсэлттэй танилцаад **аль болох хурдан** шийдвэрлэнэ.

## Бусад хүмүүс (Эхний нүүрийн 1. ②, ③-т хамрагдах хүн)

- ▶ Үндсэн ба нэмэлт тэтгэмж (зөвхөн 1. ②) авахад хүсэлт гаргах шаардлагатай.
- ▶ Хүсэлтийн маягтад дансны дугаар зэрэг мэдээлэл оруулж, шаардлагатай бичиг баримтийг хавсарган оршин суугаа газрын засаг захиргааны цонхонд **шууд өгөх** буюу **шуудангаар** явуулна уу.
- ▶ Тэтгэмж авах нөхцөл хангагдсан бол хүсэлттэй танилцаж заагдсан дансанд **аль болох хурдан** шилжүүлнэ.



## Холбогдох

“Ганц бие өрхөд зориулсан богино хугацааны тусгай тэтгэмж”-ийн лавлах төв

Утас: **0120-400-903** (Ажиллах цаг: Ажлын өдрүүдийн 09.00-18.00)

- Хүсэлт гаргах талаар дэлгэрэнгүй мэдээллийг оршин сууж буй захиргааны “Ганц бие өрхийн тусгай тэтгэмж” цонхон дээрээс авна уу.



“Ганц бие өрхийн тусгай тэтгэмж”-ийг далимдуулсан

**“Дансаар шилжүүлэх залилан” болон “хувийн мэдээлэлд халдах” гэмэт хэргээс болгоомжилно уу.**

Гэр болон ажил дээр захиргаа, халамжийн газрын ажилтны дүр эсгэсэн сэжигтэй дуудлага болон шуудан ирвэл оршин сууж буй захиргаа, ойрын цагдаагийн газар эсвэл цагдаагийн тусгай дуудлагын утсанд (#9110) мэдэгдэнэ үү.